

**Үндэсний эв нэгдэл-тусгаар тогтнол, хөгжил
дэвшлийн баталгаа болох нь**

Докторант Д.Энхцэцэг /МУИС/

Хүн төрөлхтөн нэгдмэл хийгээд хуваагдашгүй. Гагцхүү балар эрт цагаас нааш орон зайн хэмжүүрээр зааглагдан нутаг дэвсгэр хэмээх нийтлэгийн хүрээнд /өөр хоорондоо/ *харахад* зүс царай, хэл, яриагаараа ижилсэн ялгарч, цаг хугацааны хэмжүүрээр алслагдан нэгдэн нягтрах, сарнин бутрахын аль алинд өртөн мөнхийн хөдөлгөөнд оршсоор *үндэстэн* хэмээх нэгдэл үүсч, тэр нь гэр бүл цусан төрлөөс ч дутахааргүй үнэт зүйл болон төлөвшжээ.

Он жилийн урсгалд *монгол үндэстэн* хөгжиж дэвшиж, эзлэн хүчирхийлж, сарнин бутарч, эзлэгдэн доройтож, сэргэн мандсаар аугаа их түүхээ бүтээлээ. Монголчуудын хөгжил дэвшил, эзлэн хүчирхэгжиж, сэргэн мандсан баялаг түүх цадиг нь *үндэсний эв нэгдэл*, тусгаар тогтнолтой салшгүй холбоотой билээ. Засгийн дээд эрх мэдэл хийгээд төр, ард түмний нэгдмэл байдал, тогтвортой хараат бус оршин тогтнох чадвар нь тусгаар тогтнолын баталгаа болох агаад монголчууд эрт үеэс төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, дэвшил хөгжил бүхэн *үндэсний эв нэгдэл* дээр тулгуурладаг гэж үзэж ирсэн. Үе, үеийн монголчууд олон зууны туршид тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тэмцэлдээ, ". . . дотроо хямарч самуурахын үндсийг таслан, хүчээ нэгтгэхийг эрхэмлэн, эвлэхүй ёсыг барилдуулсан нь мандал бадралыг олж түүнийг умартаж огоорохын цагт сулран, "хувь заяаны доройтолдо орж" байжээ.

Энэхүү олонтой дуурсагдах "эв нэгдэл" "эе эв" хэмээх нь чухам юу болохыг монгол хэлний тайлбар тольд: "эв"- хэмээх нь хүн, амьтны хоорондын найр нийлэмж, "эв нэгдэл" гэдэг нь санаа сэтгэл явдал нийлэлцэн нэгдэх "эв нийлэх нь санаа сэтгэл найр найрамдал зохицон нэгдэх зэргээр энэ санааг "эв эе", "эв зүй" "эв найрамдал" зэрэг хоршоо үгээр илэрхийлж болдог гэжээ.

Эрдэмтэн түүхч Д.Гонгор "эе" хэмээх үгийн талаар түүний үгийн утга, хэрхэн уламжилж, өөрчлөгдөж ирсэн түүхийг судлан "эе" нь эхэн үедээ овог аймаг бүрийн эрх ашгийг хамгаалах цуглааны шинжтэй байсан бол хожим нь нийт туургатны их улсын . . . хуралдай, төрийн чуулган болсон. . . энэ бүхнээс үзвэл "эе" "хуралдай" "чуулган" *цөм л монголчуудын нэгдмэл хүчтэй байх, ололт амжилтын баталгаа нь эв нэгдэл-нэгдмэл шийдвэр гаргах явдал* багтсныг харуулж байна гэсэн нь /3;16-17/ бидний үзэж буй "эв нэгдэл нь" монголчуудын хүчирхэгжилтийн гол үндэс, төр улс оршин тогтнох, тусгаар тогтнолын баталгаа болсоор ирснийг гэрчилж буй баримт гэжээ.

Үндэсний эв нэгдэлд нэн тэргүүнээ дотоодын хүчин зүйл зөрчилдөөн, хямрал, аюул занал учруулдагийг санаж, улс үндэстнийхээ эрх ашгийн үүднээс "эв нэгдлийг хангах нь" төрийн амин чухал зорилтын нэг байсаар ирсэн. Эрт үеэс эдүгээ хүртэл түүхэн үе бидэнд монгол төр, "эв нэгдлийг хангах явдал", "эе эвийг эрхэмлэх ёсон" нь төрийн тулгуур бодлого, *төрийн хувирашгүй мөнхийн бодлого* гэж хүндэтгэн, эрхэмлэж, хэрэгжүүлж өнөөг хүрчээ.

Эдүгээ монголчууд бид дэлхийн улс түмний нэгэн адилаар шинэ мянган, шинэ зуунд дэвшин орж байна. Эхэлж буй шинэ эринд дэлхий дахинд юу тохиохыг хэн ч урьдаас хэлж чадахгүй ч, *"Даяарчлах"* бүл явц өрнөх нь дамжиггүй. Даяарчлал –одоогийн төсөөлж буйгаар дэлхийн бүх улс орнуудын хоорондын улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл боловсрол, хүмүүнлэгийн салбарын харилцаа нийтдээ уялдан өргөжиж, орон бүрийн дотоод гадаад хүчин зүйлс бие бие рүүгээ харилцан нэвтэрч, энэ том үйл явцад том гүрнүүд

тэргүүлэн оролцож эрх ашгаа илүүтээ хамгаалан зонхилох болно гэсэн үг. Иймд тэр үйл явцад идэвхтэй оролцож, тэсэн үлдэхийг бүхий л талаар хичээх нь жижиг орны ирээдүйг тодорхойлох бодлого болжээ. Иймээс монголын төрийн олон тулгуурт дотоод бодлогын нэгээхэн хэсэг нь болох “үндэсний эв нэгдлийн” үзэл чухлаар тавигдах болж байна.

Олон түмний хүч, улс нийгмийн хүч, овог, аймаг, туурга нэгт улс үндэстний хүч “эв нэгдэл” эе эвэндээ байдаг нь зөвхөн тусгаар тогтнолын асуудал төдийгүй түүний цаана эх орны хөгжил дэвшил, ирээдүй тулгуурлах болно гэдгийг өнөөдөр ч гэсэн ухамсарлан:

Үндэсний эв нэгдэл нь- монголчууд бидний тусгаар тогтнолын баталгаа-хөгжил дэвшил, сэргэн мандалтын эх сурвалж мөн гэж үзсээр байна. Тийм ч учраас эв нэгдлийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох, “үндэсний эв нэгдэл” монгол улсын үндэсний язгуур эрх ашиг болох тухай төрийн хууль, тогтоомжуудад хуульчилан баталж өгсөн нь санамсаргүй, тохиолдлын зүйл биш бололтой.

“Монгол улсын Үндсэн хууль” (1992). “...Эх орны тусгаар тогтнолыг батлан хамгаалах, үндэсний эв нэгдэл, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний эв нэгдлийг нэгэн түвшинд онцгойлон авч үзжээ. Мөн УИХ-аас батлан гаргасан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д (1994) : “Монгол үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг “... монголын ард түмний соёл иргэншил оршин тогтнох, монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхэт байдал, нутаг дэвсгэр... хил хязгаарын дархан байдал... гэхийн хамт “Үндэсний эв нэгдэл” юм /2;1-2/ гэж томъёолжээ. Энэ бүхнээс үзвэл, хүн төрөлхтөний шинэ 3 дахь мянган жилийн эхэнд улс түмнүүдэд дан ганц цэрэг дайны шинжтэй төдийгүй, улс төр, эдийн засаг, хүн ам, экологийн гаралтай аюул заналхийлэл нэмэгдэн “Үндэсний эв нэгдлийг хангах нь “ үндэсний аюулгүй байдлын (ҮАБ-ын) бодлого үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл тусгаар тогтнолын баталгаа болжээ гэж дүгнэж болох юм.

Тэгвэл, өнөөдөр, Монголд, үндэсний эв нэгдэл задарсан уу? Үндэсний эв нэгдэл тусгаар тогтнолд ноцтой аюул занал учирсан уу? дотоодын хямрал зөрчилдөөн гарч ҮАБ, улс орон оршин тогтноход аюул учруулав уу? үгүй юу? гээд олон асуулт гарч болох юм. Үүнд, шууд утгаар “үгүй” гэж хариулж болно. Нийтлэлчид, судлаачдын зарим нь үндэсний эв нэгдэл тусгаар тогтнол, аюулгүй байдалд ноцтой хохирол учруулаагүй тул өнөөдөр ҮАБ-ын амин чухал асуудал бол эдийн засгийн аюулгүй байдал, байгал экологи, хүнсний аюулгүй байдал чухал хэмээн бичиж байна. Дээрх асуудалтай холбоотой өнөөдөр Монгол улс, улс төрийн хувьд ч, нийгэм болон угсаатны хоорондын харьцангуй тайван тогтвортой байдалд оршиж байна. (Бидний хийсэн судалгаанд оролцогсодын 70 гаруй хувь нь үүнтэй бас санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн).

Улс төрийн нам хөдөлгөөнүүд гол төлөв улс орныхоо цаашдын хөгжлийн замыг сонгох асуудлаар санал зөрүүтэй байгаагаас улс төр, дотоодын хүндрэл тодорхой хэмжээгээр байгаа ч тэр нь дотоодын юуны өмнө улс төрийн болон угсаатан хоорондын ноцтой мөргөлдөөний аюулыг бий болгоогүй байна. Энэ нь ардчилсан хүчнийхэн дэвшүүлж бусад улс төрийн хүчнийхний дэмжлэгийг хүлээсэн” Монгол үндэстний сэргэн мандалт, хөгжил дэвшилд хүрэх хүн ардын сайн сайхны төлөө улс орноо ардчилсан замаар хөгжүүлье! “ гэсэн үзэл санаа хүн амын бүх давхраа үндэстэн, ястны, нийгмийн бүлэг, улс төрийн хүчнүүдийг нэгтгэн нягтруулах “Үндэсний эв нэгдлийг “ хангах иргэний нийгмийг төлөвшүүлэх үндэс болж байна. Нөгөө талаар ойрын жилүүдэд монголд

шашны зан суртхууны болон угсаатан хоорондын зөрчил байхгүй, монгол үндэстний нэгдмэл байдалд ноцтой аюул нүүрлэж байсангүй гэж хэлж болно. .

Өнөөдөр яагаад үндэсний эв нэгдлийг хангах тухай, үндэсний эв нэгдлийн асуудлыг төрийн хэмжээнд авч үзэж, “Үндсэн хууль” болон бусад тулгуур баримт бичгүүдэд тусгай заалт оруулж, өдөр тутмын хэвлэлд үндэсний эв нэгдлийн тухай бичих, ярих, анхааруулан маш олонтоо дурьдах болов оо? гэсэн асуулт гарч байна. Бид чухам үүнд л зарим нэг хариулт өгөхийг хичээсэн юм. Үүнд:

Нэгдүгээрт : Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилт туйлын өргөн хүрээтэй ойлголт юм. Монгол улсын тусгаар тогтох, бүрэн эрхт байдалд: өнөөдөр дан ганц-цэрэг зэвсгийн заналхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төдий бус, Монгол улсын оршин тогтнох нийгэм төрийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөө, эдийн засаг, шинжлэх ухаан –технологи, мэдээлэл, монгол иргэншил хүн ам-удмын сан, экологийн аюулгүй байдалтай нягт холбоотой өргөн асуудлыг хамаарч байдаг тул ҮАБ-тай холбоогүй хүрээ (нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны) огт байдаггүй. Гэтэл XXI зууны босгон дээр жижиг улс, үндэстний хувьд, түүний дотор монгол орны хувьд ч: “Үндэсний аюулгүй байдал” “хөгжлийн асуудал” ямагт нэгдмэл шийдэгдэх болно. Энэ нь гадны аюул заналаас өөрийгөө хэрхэн хамгаалахаас илүү улс үндэстэн оршин тогтнох гадаад дотоод тоотой нөхцлийг бүрдүүлэх, бий болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэл чухал болжээ. Хэрэв өөрийгөө хамгаалахгүй юм бол, хэн ч “том гүрэн ч” өмгөөлөхгүй, өмгөөлүүлэх нь тухайн улс орны эрх ашигт нэн харш гэдгийг олон улсын амьдралаас тодорхой харагдаж байна. Харин ийм нөхцөлд жижиг орны тусгаар тогтнох чадавхи, тусгаар тогтнолын баталгаа нь:

1-рт: Олон улсын харилцааны механизмыг бүрэн дүүрэн ашиглах

2-рт: Дотоодын эв нэгдлээр тодорхойлогдох нь маргаангүй ажээ.

Тухайлбал, улс орнууд аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? гэсэн асуултанд 1997 онд Азийн 10 гаруй орны иргэдийн дунд явуулсан судалгаанд нийт оролцогсодын 30 хувь нь хэн нэгэнд найдах бус, улс орон бүр өөрийгөө бие дааж хамгаалах явдал гээд гол нь дотоод хүчин зүйл:

1-рт: улс орны эдийн засгийн тогтвортой байдал

2-рт улс үндэстнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх явдал болно (5;23) гэж хариулсан нь тохиолдлын зүйл биш юм.

Хоёрдугаарт: Үндэсний аюулгүй байдалд учруулж болох аюулын магадлал, учруулах бодит аюулын хэмжээ харилцан адилгүй тул, болзошгүй аюулын нөхцлийн бүрдэлт байдлаар нь судлаачид 3 шаталбараар:

1. Сэтгэл түгшээх хэмжээний

2. ҮАБ-д нөлөөлөх сөрөг үзэгдэл гарах хэмжээний

3. Аюулын магадлал бий болсон гэж ангилсан байдаг.

Энэ шаталбараар авч үзвэл, үндэсний тусгаар тогтнол, улс орны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, “эв нэгдэл” сулрах, “эв нэгдлийг бусниулах хүчин зүйл хэдийгээр шууд бус ч сэтгэл түгшээх хэмжээний төвшинд байна гэж үзэж болох юм.

Манай улсад 1997 онд Сант-маргад сангаас ҮАБ-ын талаархи судалгаанаас үзвэл:

1. Манай улсад заналхийлэн буй аюул заналхийлэл байна уу? гэсэн асуултад нийт оролцогсодын 62.8 хувь (5;23) -*тийм байна* гэжээ.

2. Тийм бол ямар хүчин зүйл байна вэ? гэсэн асуултад 63.3 хувь (5;23) дотоодын хүчин зүйл гээд улс орны аюулгүй байдлыг хангах таатай нөхцөл,

эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь зөв. Үүний баталгаа нь *тогтвортой хөгжил* гэж онцлон тэмдэглэжээ. Энэ нь *улс төрийн ба нийгмийн тогтвортой байдлыг* хангах болно гэж үзжээ. Үүнээс улбаалан авч үзвэл:

- Эдийн засгийн тогтворгүй байдал, нийгэм төрийн хямрал үүсэх, үндэсний эв нэгдэл задрах, ҮАБ-д нөлөлөх хүчин зүйл болохыг харуулж байна. Шууд бус утгаар *"Үндэсний эв нэгдэл нь-тусгаар тогтнолын баталгаа"* гэсэн санаа давхар ажиглагдаж байна. Үүнийг үндэслэн 2002 онд бидний явуулсан санал асуулгаас үзвэл:

- ҮАБ, тусгаар тогтнол, Монгол улсад заналхийлж буй дотоод хүчин зүйл байна уу? байвал ямар асуултууд байна вэ ? гэсэн асуултанд

- Эдийн засгийн доройтол

- Буурай хөгжил

- Ажилгүйдэл

- Ядуурал нэмэгдэх

- Экологийн хямрал

- Шашны урсгалууд нэвтрэх

- Хүний эрх эрх чөлөө зөрчигдөх

- Гэмт хэргийн өсөлт гээд өнөөгийн нийгмийн амьдралд тулгарч буй олон хүндрэл бэрхшээлийг дурьджээ.

Эцэст нь эдгээр хүчин зүйлийн цаад үр дагавар юу болох вэ? гэсэн асуултанд нийт оролцогчдын 60-65 орчим хувь нь:

- Энэ бүхэн нийгмийн тогтворгүй байдлыг бий болгож болзошгүй улмаар, үндэсний эв нэгдэлд шууд бусаар нөлөөлөхийг үгүйсгэхгүй байна гэж хариулан.

Дээр дурдсанаар үндэсний эв нэгдлийн асуудал нийгмийн сэтгэлзүйн хувьд *сэтгэл түгшээх түвшинд байгаагийн хөдлөшгүй баримт болж байна.*

Гүрэгдугаарт: Үндэсний эв нэгдлийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг үндсэн хуулиндаа заасан. "Монгол улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл бөгөөд тухайн улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр *тэгш эрх эдлэх нь үндэсний эв нэгдлийг хангах баталгаа юм.*

Гэтэл зарим тохиолдолд энэ баталгааны жинхэнэ үнэ цэнийг алдагдуулж, шударга тэгш бус байдал гарч нийгмийг бухимдуулж *буй нь олон түмний сэтгэлийг түгшээх нэг зүйл* болж байна. Энэ талаар сүүлийн 1 жил гаруй хугацаанд гол 3 хэвлэлийн нийтлэлүүдийг нягтлан үзвэл, хүмүүс өөрийн эрх ашиг хөрөнгө чинээний байдал, эрхэлсэн ажил, үзэл бодол, нутаг усаараа ялгарах, талцах явдал байгаа тухай болон улс төрийн суулт, ажил хаялт, элдэв холбоо, байгуулагдаж байгаа талаар тэмдэглэж байна. Мөн үндэсний эв нэгдлийг хангах тухай, үндэсний амин чухал эрх ашиг "эв нэгдэл" байх тухай дурьдан мэдээллийн тоо олон арваар тоологдож байгаа зэргийг дурьдаж болох юм.

Дээрх бүхнийг дүгнэвэл; Монгол улсын үндсэн тулгуур баримт бичгүүдэд томъёолсон үндэсний эв нэгдлийг хангах явдал нь монголчуудын нийгэм, улс төрийн тогтвортой байдлыг хангах, тусгаар тогтнол, хөгжил дэвшил бүхний баталгаа болох нь дамжиггүй.

Эв нэгдэлт монгол үндэстэн мандан бадрах, уруудан доройтохын алинд ч хүний ертөнцийн нийтлэг тавилангаас гажиж зөрсөн нь үгүй, монголчуудын ухаант өвөг дээдсийн, монгол төрийн үндэсний "эв нэгдлийн" *түүхийг*

улируулан судлах нь өнгөрсөн өнөөдөр ирээдүйг холбох бас нэг чухал шижим болох ажээ.

Ном зүй

1. "Монгол улсын Үндсэн хууль" УБ., 1992
2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ., 1994
3. Д.Гонгор "Халх товчоон" УБ., 1973. /I боть/.
4. Очирбат. "Монгол төрийн үзэл нь эв нэгдлийн үзэл" Ардын эрх сонин. 1995.12.15
5. "Монгол улсын аюулгүй байдал" УБ., 1999
6. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шинжлэх ухааны үндэслэл. /Эрдэм шинжтлгээний хурлын эмхэтгэл/ УБ., 2001.